



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 07 сарын 26 өдөр

Дугаар 222

Улаанбаатар хот

Г “Евразиа капитал монголиа” ХХК-ийн 7
тусгай зөвшөөрлийг сунгах, тусгай зөвшөөрлийг
нэмж олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5, 15.3.5 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Евразиа капитал монголиа” ХХК-ийн үнэт цаасны зах зээлд брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2011 оны 8 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаагаар сунгасугай.

2. “Евразиа капитал монголиа” ХХК-д үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нэмж олгосугай.

3. Хөрөнгө оруулагчид, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлэн ажиллахыг “Евразиа капитал монголиа” ХХК-ийн /Г.Оюунболд/-д үүрэг болгосугай.

4. Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /С.Тулгаа/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН